

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Улсын Их Хурлаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг 2002 онд баталжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1961 онд баталсан Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц, 1971 онд баталсан Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, 1988 онд баталсан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид Монгол Улс нэгдэн орсон¹ бөгөөд үндэсний хууль тогтоомжийг эдгээр конвенцид нийцүүлэх үүргийг хүлээсэн байдаг.

Улсын хэмжээнд 2021-2025 оны эхний хагас жилд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 1021 гэмт хэрэгт 987 иргэн холбогджээ. Түүнчлэн, сүүлийн 8 жилийн хугацаанд шүүхээр 992 хэрэгт, 1479 иргэн шийтгэгдсэн байна.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар 112 гэмт хэрэг бүртгэгдэж, 97 иргэн яллагдагчаар шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5 хувиар өсөж, тус гэмт хэрэгт холбогдогчдын 51 хувийг 13-25 насны хүүхэд, залуучууд эзэлж байна.

Түүнчлэн, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын төрөл нэмэгдэж, химийн гаралтай мансууруулах бодисыг үйлдвэрлэх аргачлалыг цахим орчин болон бусад эх сурвалжаас олж авч дотооддоо хууль бусаар боловсруулж, хэрэглэгч улсаас үйлдвэрлэгч улс руу шилжих бодит эрсдэл үүссэн.

Ийнхүү Монгол Улс дахь хар тамхины хэрэглээ, гэмт хэрэг, зөрчил жил ирэх тусам өсөж, улмаар монгол хүний амь нас, эрүүл мэнд, удмын санд ноцтой хор уршиг учрах эрсдэлтэй нөхцөл байдалд хүрсэн, хар тамхинд донтсон хүнд эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээ үзүүлэх асуудал орхигдсон, мөн хуулиар мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн, тодорхой зохицуулаагүйгээс далд нууц, зүй бус эргэлтийн эрсдэлт байдал их, түүнчлэн олон улсын гэрээнд заагдаагүй шинэ төрлийн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис ихсэж, хэрэглэгдэх болсон, шинэ төрлийн бодис нь олон улсын гэрээнд заасан жагсаалтад байхгүй гэдэг үндэслэлээр гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдалтай байсаар байна.

Дээрх нөхцөл байдал нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилтыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн зохицуулалт хангаж чадахгүй байгааг харуулж байна.

¹Монгол Улс Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенцид 1999 онд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенцид 2003 онд тус тус нэгдэн орсон.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 29 дүгээр тогтоол гарсан ба тус тогтоолд хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан, үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэм этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, үйлчлэл болон бусад объектив талыг харгалзан ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг чангаруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг таниулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулан яаралтайгаар боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг өгөгдсөн билээ.

Ерөнхий сайдын 2025 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 49 дугаар захирамжаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус Ажлын хэсэг 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр хуралдаж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/386 дугаар тушаалаар байгуулагдсан тус хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгээс боловсруулсан хуулийн төсөлтэй танилцаж, тус хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/386 дугаар тушаалаар байгуулагдсан тус хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгээс энэхүү хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу холбогдох судалгаануудыг Хууль зүйн үндэсний хүрээлэнд захиалан хийлгэсэн бөгөөд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийлгэсэн.

Тус ажлын хэсгээс судалгааг үндэслэн, түүнчлэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, гарч буй хүндрэлт байдал, бусад шаардлагатай нөхцөл байдлыг тодорхойлохыг зорьж, холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй, тухайлбал, эм, эмнэлгийн хэрэгсэл, гааль, хил хамгаалах, шүүх шинжилгээ, байгаль орчин, мал, амьтны эм зэрэг бусад холбогдох асуудал хариуцсан газрын мэргэжилтэн, удирдах албан тушаалтнуудтай уулзалт хийж, асуудлыг тодруулан ажиллаж хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудаснаа 2024 оны 5 дугаард сард байршуулан иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулж, хуулийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлэн ажиллалаа.

-----oOo-----